

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2025.07.18

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /АХОЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

АХОЗШША-ны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Шилэн дансны үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **91%-тай** үнэлэгдлээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Сайд, ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгавар байхгүй тул үнэлгээнд оруулаагүй болно.

2.1. АХОЗШША-ны 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
16	8	5	-	1	1	-	1	88,6%

2.2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%			
төсөв, гүйцэтгэл	7	4	-	-	-		3	100%
хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт	3	3	-	-	-		-	100%
бусад	8	8	-	-	-		-	100%

Нийт	18	15	-	-	-	3	100%
------	----	----	---	---	---	---	------

2.3. Ил тод, нээлттэй байдлын шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээ:

Мэдээлэл	Нийт заалт	Үүнээс					Биелэлтийн хувь
		100%	70%	30%	0%	хамаа ралгүй	
Нийт	45	9	-	1	1	34	84,5%

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

1. Төлөвлөлтийн байдал:

АХОЗШША нь ХШҮДАГ-аас өгсөн зөвлөмжийн дагуу 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг ЗТХЯ-ны Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулж, хүрэх түвшинг улирал бүрээр төлөвлөн Зам, тээврийн яамны холбогдох газруудаар хянуулж, батлан ажилласан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам” шинэчлэн батлагдсантай холбоотой байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2. Хэрэгжилтийн байдал:

- 1) АХОЗШША-ны 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Шилэн дансны үнэлгээ, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 3 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **91%-тай** үнэлэгдлээ.
- 2) Албаны бүтэц, орон тоо, дүрмийг яаралтай шинэчлэн 2025 оны I сард багтаан батлуулах зөвлөмж хэрэгжсэн байна.
- 3) 2025 оны эхний хагас жилд зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны хүрээнд аюулгүй байдлын 4 зөвлөмж гаргасан. Нийт хяналтад байгаа 22 зөвлөмжөөс 20%-тай 2, 30%-тай 10, 50%-тай 1, 90%-тай 1, хэрэгжээгүй 4, хугацаа болоогүй 3 зөвлөмж, дундажаар 26,6%-ийн хэрэгжилт байна.
- 4) Шинжлэн шалгах ажиллагаанд шаардагдах тоног төхөөрөмжийн жагсаалт, шинжлэн шалгахчдын хувцас хэрэглэлийн судалгаа гарган хөдөлмөр хамгааллын хувцас болох өвлийн хүрэм, өмд, гутал зэрэг хувцас авах зардлыг шийдвэрлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.
- 5) Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх судалгаа хийсэн боловч төсөв санхүүгийн асуудал шийдэгдээгүй тул хэрэгжээгүй хэвээр байна.

Дөрөв. Санал, зөвлөмж

1. Шинжлэн шалгах ажиллагаанд дэвшилтэт техник технологи, инновацыг нэвтрүүлэх зардлыг төсвөөс гадна гадаад орон олон улсын байгууллагын тусламж зэрэг өөр эх үүсвэрээр шийдвэрлэх талаар санаачлалтай ажиллах;

2. Аюулгүй ажиллагааны зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэн тайланг улирал бүр Зам, тээврийн яаманд ирүүлэх;
3. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтээр хангалтгүй үнэлэгдсэн болон зөрчлийг бүртгэх, мэдээлэх, цахимжуулах үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлэх;
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэхдээ дараах зүйлсийн анхаарах. Үүнд:
 - Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд АХОЗШША, яам болон ИНЕГ-ын оролцох үүрэг, хариуцлагыг ялгаатай тодорхойлж, хэрэгжүүлэх хугацааг уялдуулах.
 - Суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР